



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

### Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг газрын Удирдлагын зөвлөлийн хуралд 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ